**“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТҮГ-ЫН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

***А/ ТАНИЛЦУУЛГА***

| | |
|---|---|
| **1.Байгууллагын нэр:** “Үндэсний дата төв” УТҮГ | **2. Нэгжийн нэр:** Мэдээллийн аюулгүй байдлын газар |
| **3. Ажлын байрны нэр:** Газрын дарга | **3.1. Албан тушаалын ангилал**: Газрын дарга |
| **4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:** Захирал | **4.1. Албан тушаалын ангилал:** Захирал |
| **5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал:**<br>• Газар болон хэлтсийн ажилтнууд | **5.1. Албан тушаалын нэр, тоо:**<br>• Газар хэлтсийн нийт ажилтнууд -16 |

***Б/ ЧИГ ҮҮРЭГ***

| | |
|---|---|
| **1. Ажлын байрны зорилго** | Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын стратеги бодлого журам болон байгууллагыг кибер халдлагаас, сэргийлэх хамгаалахтай холбоотой шийдвэр гаргалтыг хариуцан, хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл арга зүйгээр хангах; |

| **2. Ажлын байрны үндсэн зорилт:** | **2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт:** |
|---|---|
| 1. Мэдээллийн аюулгүй байдлын хангах бодлого, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаас хангах ; | 1. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо олон улсаны стандартын дагуу бүрдсэн байна. |
| 2. Нэгжийн үйл ажиллагааг удирдлага манлайллаар хангах, албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих үнэлгээ хийх; | 2. Нэгжийн үйл ажиллагааг тасралтгүй төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжсэн байна. |
| 3. Кибер халдлага, зөрчлийн үед хариу үзүүлэх баг болон шаардлагатай систем, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, бэлтгэх; | 3. Кибер халдлага, зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авах баг, систем, тоног төхөөрөмж бэлтгэгдсэн, бэлэн байдал хангагдсан байх; |
| 4. Байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | 4. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх; |

| 1. **Ажлын байрны гол үйл ажиллагаа:** | **3.1. Хугацаа, хувиар** |
|---|---|
| **<u>Ажлын байрны 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд:</u>**<br>1.1. “Үндэсний дата төв”УТҮГ-ын мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой бодлого, дүрэм, журам заавар боловсруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;<br>1.2. Мэдээллийн аюулгүй байдал, төрийн нууц, байгууллагын нууцын тухай болон холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих | 30 % |
| **<u>Ажлын байрны 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u>**<br>2.1 Төвийн сүлжээ, систем өгөгдлийн сан, программ хангамжийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах; | 30 % |

| | |
|---|---|
| 2.2 Төрийн мэдээлэл солилцооны системийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах;<br>2.3 "Үндэсний дата төв"УТҮГ-ын орчны аюулгүй байдалд хяналт тавих дүн шинжилгээ хийх, шаардлагатай арга хэмжээг авах;<br>2.4 Мэдээллийн технологийн аудит хийх зохион байгуулах;<br>2.5 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах криптограф, нууцлалын программ хангамжийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж,ашиглалтыг хариуцах;;<br>2.6 Халдлага эсэргүүцэх багийн үйл ажиллагааг зохион байгуулах;<br>2.7 Мониторингийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;<br>2.8 Монголын интернетийн харилцан холболтын зангилаа төвийн сүлжээний урсгалын аюулгүй байдлыг хяналт тавих, дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагуудад тайлагнах ажлыг зохион байгуулах;<br><br>**<u>Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u>**<br>3.1 Төрийн байгууллагуудын хэмжээнд мэдээлэл технологийн аюулгүй байдлын судалгаа хийх дүн шинжилгээ хийх, төвийн үйл ажиллагаанд ашиглах;<br>3.2 Мэдээллийн технологийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах ;<br>3.3 Олон улсын болон дотоодын эрх бүхий байгууллагуудаас үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой тусгай зөвшөөрөл, лиценз, сертификат бусад эрхийн баримт бичгүүдийг авч ашиглах, сунгалтуудыг хийх;<br>3.4 Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар шинэ технологи, үйлчилгээний талаар судалгаа хийх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;<br><br>**<u>Ажлын байрны 4 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u>**<br>4.1 Салбарын хэмжээнд бодлого, хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлж зөвлөмжөөр хангах;<br>4.2 Байгууллагын дотоод үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм журмыг боловсруулахад санал оруулах, хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх;<br>4.3 Удирлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд ажлуудыг төлөвлөх, ажилтнуудад хуваарилах удирдлагаар хангах дэмжлэг үзүүлэх хэрэгжилтийг хангуулах; | <br><br><br><br><br><br><br><br><br>30 %<br><br><br><br><br><br><br><br><br>10 % |

***<u>B. ТАВИГДАХ ШААРДЛАГА:</u>***

| **1. Ажлын байранд тавигдах шаардлага** | **1.1. Ерөнхий шаардлага:** | **Үзүүлэлт** | **Чухал шаардлагатай** | **Шаардлагатай** |
|---|---|---|---|---|
| | | **Боловсрол** | Бакалавр | Магистр болон түүнээс дээш |
| | | **Мэргэжил** | Мэдээллийн технологийн инженер | Мэдээллийн аюулгүй байдлын инженер |
| | | **Мэргэшил** | Мэдээлэл, сүлжээ, системийн аюулгүй байдлаар гүнзгийрэн мэргэшсэн | Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлийн мэргэшсэн сертификаттай байх /GIAC, OffSec г.м/ |
| | | **Туршлага** | Мэргэжлээрээ 12-оос доошгүй жил ажилласан,үүнээс 10 болон түүнээс дээш хүнтэй бага удирдаж 3-аас доошгүй жил ажилласан байх; | Мэдээлэл технологийн аюулгүй байдлын чиглэлээр төсөл хөтөлбөр удирдан хэрэгжүүлсэн туршлагатай байх; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Ур чадвар** | Сүлжээ, сервер, системийн аюулгүй байдлыг зохион байгуулахад шаардлагатай техник хэрэгслүүдийг ахисан түвшинд эзэмшсэн байх,<br>Англи хэлний мэдлэгтэй байх;<br>Багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай байх | Төсөл хөтөлбөр, шийдэл боловсруулах, хэрэгжүүлэх<br>Англи хэлний ахисан болон түүнээс дээш шатны мэдлэгтэй байх; |
| | **1.2. Тусгай шаардлага:** | | Харилцааны өндөр соёлтой байх;<br>Үнэнч шударга ажиллах;<br>Төрийн болон байгууллагын нууц хадгалах, зөвшөөрөлгүй мэдээлэлд нэвтрэхгүй байх, ёс зүйн хэм хэмжээг сахих, ажлын байрны цэвэр, цэгцтэй байдлыг хангах; | Ажлын ачаалал даах чадвартай байх; |

***Г.ХҮЧИН ЗҮЙЛС:***

| **1. Ажлын байрны харилцах субъект** | |
|---|---|
| **1.1 Байгууллагын дотор талд байгаа**<br>- Захирал<br>- Газрын дарга<br>- Хэлтсийн дарга<br>- Мэргэжилтнүүд<br>- Ажилтан | **1.2. Байгууллагын гадна талд байгаа**<br>**Шууд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу харилцах байгууллага:**<br>• Үндэсний аюулгүй байдлын зөвлөл<br>• Цахим хөгжил, инновацын харилцаа холбооны яам<br>• ТЕГ Мэдээллийн аюулгүй байдлын газар<br>• Төрийн тусгай хамгаалалтын газар<br>• Мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага аж ахуй нэгж, иргэн<br>**Шууд бус харилцах байгууллага**<br>- Байгууллага, аж ахуй нэгж, иргэн |
| **2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага:** | Эрхэлсэн ажлынхаа хүрээнд "ҮДТ" УТҮГ-ын захирал, Мэдээллийн аюулгүй байдлын газрын даргын өмнө хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ. |

| | | |
|---|---|---|
| **3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл:** | **3.1. Санхүүгийн** | Үндсэн ба илүү цагийн цалин хөлс, хоол, унааны мөнгө болон урамшуулал, гадны санхүүжилттэй ажилд оролцох үед гүйцэтгэсэн ажлын хэмжээтэй дүйцэхүйц урамшуулал |
| | **3.2. Материалын** | Интернэт холболт, ажлын хэрэгцээний ширээ, сандал бусад тавилга хэрэгсэл, компьютер, холбогдох техник хэрэгсэл, бичиг хэргийн материал, Цахим оффисын системийн эрх |
| | **3.3. Хүний** | - |
| | **3.4. Бусад** | - |
| **4. Ажлын байрны нөхцөл** | **4.1. Ердийн нөхцөл** | Хэвийн |
| | **4.2. Онцгой нөхцөл** | - |

***Д. БАТАЛГААЖУУЛАЛТ:***

| **Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч** | **Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан** |
|---|---|
| Албан тушаалын нэр:<br>“Үндэсний Дата Төв” УТҮГ-ын Захиргаа, удирдлагын газрын дарга<br>.............................. Ө.ГАНТУЛГА<br>/гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр/<br>20... оны ... сарын ...-ны өдөр | Албан тушаалын нэр:/тамга/<br>“Үндэсний Дата Төв” УТҮГ-ын Захирал<br>.............................. М.БАТТУЛГА<br>/гарын үсэг/ /Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр/<br>20... оны ...сарын ...-ны өдөр |